

ГЭР БҮЛИЙН МАРГААН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЖ БОЛОХ УУ?

IS IT POSSIBLE TO PREVENT FAMILY DISPUTE AND VIOLATION?



Т.НАМЖИЛ Гэр бүл судлаач, шинжлэх ухааны доктор, профессор

NAMJIL T. Scientist on family, Sc.D, professor

Abstract: It is necessary to pay attention on the improvement of family communication because of crucial cycle of Mongolian family development. Here we advise you how to prevent family violation and offences that caused by the dispute and violation.

Монгол Улсын “Эвлэрүүлэн зуучлалын тухай” хуульд (2012 он) үйлчлэх хүрээг заахдаа: “... гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ” гэж заажээ.

Гэр бүлийн харилцаа

- Бодох нэгэн зүйл
- Бас бодох нэгэн зүйл
- Өөр нэгэн бодох зүйл

Монгол гэр бүлийн хөгжлийн эгзэгтэй үед гэр бүлийн харилцааг хөгжүүлэхэд нийтээрээ зайлшгүй анхаарах шаардлага, хэрэгцээ урган гарсаар байна. Тиймээс гэр бүлийн маргаан, түүнээс үүдэн гарах хэрэг, зөрчил, хор уршгаас урьдчилан сэргийлэх зөвлөгөөг уншигч Та бүхэндээ хүргэж байна.

Бодох нэгэн зүйл

Бүсгүй хүүхэд хоёр юм уу гурван ахтай бол эмэгтэй охин дүү нь ах нартаа нэлээд эрхлэнгүй өсч торнино. Ах нар нь охин дүүгээ чадлын хэрээр хайрлаж, багагүй анхаарал тавина. Тэгвэл: Бүстэй хүүхэд хоёр юм уу гурван эгчтэйгээ нэг гэрт өссөн гээд бод доо. Тэр эр хүн нэлээд эрхлэнгүй, зөөлөвтөр зан араншинтай болно доо.

Тэгэхээр:

Нэгэн гэрт эгч, ах, дүү нар хамтдаа өсч бойжино гэдэг бүхэлдээ сурган хүмүүжлийн үйл ажиллагаа

явагдсаар байдаг гэсэн үг. Аль ч эгч, ах нар нь ижий, аавын сурган хүмүүжлийн чухал үүргээс өөрт нь үл мэдэгдэм байдлаар үүрч дүү нартаа сурган хүмүүжүүлэгч болж, үүний хажуугаар өөрсдөө сурч, хүмүүжиж, туршлагажиж эхэлдэг байна. Ийнхүү гэр бүлийн дотоод харилцаанд бие биедээ нөлөөлөх тасралтгүй урсгал бий болжээ. Жишээлбэл: айлын том охин, айлын бага хүүтэй ханилжээ. Айлын том охин дүү нартаа ханддаг байсан шигээр нөхөртөө ханддаг. Гэтэл айлын бага хүү бусдаар хайрлуулж, энхрийлүүлэх дуртай байдаг. Тэгэхээр нөхөр болсон /хүү /нь айлын том охин /эхнэрээрээ/ халамжлуулах эрмэлзэлтэй. Эхнэрээрээ бүх зүйлийг хийлгэх гээд байдаг. Ер нь эр хүн /хүү/ үглээнд дургүй. Ингэхлээр та бүхэн мэдмээр сонин асуулт гарч ирж байна. Дээрх эхнэр, нөхрийн харилцаанд / өөрсдөд чинь үл мэдэгдэм/ зөрчил үүсч байгаа юм.

Зөрчил үүсгэх учир

- Та айлын хэддэх хүүхэд болж өссөн билээ?
- Соёл иргэншлийн ялгаа
- Хоёр өөр орны хүмүүс хоорондоо суудаг
- Хотын хүн, хөдөөгийн хүнтэй суудаг
- Айл гэр бүлийн өөрийн гэсэн онцлог зэргээс шалтгаална.

Тэгвэл юуг анхаарвал зүйтэй вэ?

- Та өөрийн гэр бүлийнхний овогтны зан заншлын уламжлалын онцлогоос аль болох мэдэхийг хичээх (нэг газар эр хүнийг их хүндэлдэг байхад нөгөө

нутгийнхан эмэгтэй хүнийг дээдэлдэг жишээтэй). Үүнд гадны нэг жишээ авъя л даа. Энэ жишээ бол жижигхэн мэт та нарт санагдаж болно. Аав юм уу ижий нар нь өглөө орыг нь хураадаг, орой засдаг байсан айлын охин, хүү гэрлэжээ. Тэр хоёр гэрлэлтийн дараахи аялалд нэгэн газрын буудалд хонох болжээ. Унтах болж. Эхнэр, нөхрийн аль нь ч ороо засах гэсэнгүй. Зассангүй. Тэгээд хоёул бие биенээ хараад суусаар шөнө болгожээ. Энэ нь жижиг мэт харагдавч ойлгомоор зүйл байгаа биз.

Эхнэр, нөхөр хоёр харилцан ойлголцохгүй бол яван явсаар харилцааны зөрчилд хүрнэ. Та өөрөө айлын хэд дэх хүүхэд болж төрснөөс хамаарч, шинээр үүссэн хосуудын зохицолдлогоо өөр болж ирнэ.

Нэг өдөрт эмэгтэй хүн 5000 үгийг, эрчүүд 500 үгийг яриандаа хэрэглэдэг байна. Эрэгтэй хүн “ярилцана” гэдгийг зөвхөн асуудалтай үед л ярилцдаг гэж боддог. Эхнэр хүн нөхрийгөө ажлаас ирэхэд өнөөдрийн бүх зүйлийг ярих (ярилцах) гэдэг. Эрэгтэй (нөхөр) хүн яриаг нь төдий л сонсдоггүй байна. Ингэхэд нь эмэгтэй (эхнэр) хүн гомдолдог. Гэтэл эрчүүд ажил дээрээ 500 үгээ аль хэдийн хэрэглэчихдэг. Тиймээс гэртээ ярих үггүй шахам болоод ирдэг. Эмэгтэй (эхнэр) хүнийг ярихаар эр хүн “Тэгээд яагаав” гээд үргэлжлэх их яриаг зогсоодог. Ингэхийн оронд нөхөр нь: их ядарсан ч эхнэрийнхээ сэтгэлийг ойлгож “Өө тэгсэн үү?” гэх жишээтэй үг хэлэх хэрэгтэй болно доо. Эмэгтэй хүн нөхрөө “Миний үгийг анхааралтай сонсоод ярилцаасай” гэж боддог онцлогтой. Эхнэр нь ажлаасаа ирээд нөхөртөө “Би бүр ядарчихлаа” гээд хэлэхэд, нөхөр нь “Тэр ажлаасаа гарахгүй юу” гэх жишээтэй. Харин энэ үед эхнэр нь нөхрөөсөө “Үнэхээр их ядрал уу одоо сайхан амар даа” гэж хэлэхийг хүсдэг. Эсвэл ядраад толгой өвдөөд байна гэж эхнэрээ хэлэхэд нь нөхөр нь “Эм уугаад унт” гэдэг байна. Тэгэхэд эхнэрт нь ярих зүйл байхгүй болдог. Үүнийг нөхөр нь асуудал шийдэгдчихлээ гэж боддог. Үнэндээ бол асуудал шийдэгдээгүй, эхнэр нь дотроо гоморхолтой үлддэг.

Тэгэхээр:

Эр хүн эмэгтэй (эхнэр) хүний сэтгэлийг ойлгох хэрэг гарч байгаа биз! Үүнийг л давбал хоёул улам ойртдог. Эмэгтэй хүн эрчүүдээс “Миний сэтгэлийг ямагт ойлгоосой, мэдрээсэй” гэдэг. Эр хүн эмэгтэй хүнээс магтаал сайшаалыг хүсдэг. Эмэгтэй хүн эр хүнийг чухам юунаас нь эхэлж магтахдаа мэдэж байх хэрэгтэй. Эхнэр нь тэтгэвэрт гарсан нөхрийгөө: нэгэн өглөө цээжээ нойтон алчуураар арчиж байгааг хараад гарын булчинг нь “Миний өвгөн чинь овоо булчинтай юм” гэж хэлжээ. Өглөөний цайгаа уух гэтэл өвгөн нь алга. Хаачсан юм бол? Гээд хайтал нөгөө өрөөнд гантил өргөчихсөн зогсож байсан гэнэ. Тэгэхээр үг гэдэг харилцаанд хүчтэй нөлөөлдөг болох

нь харагдаж байгаа биз.

Өөр бодох нэгэн зүйл

Эрчүүд хүлээн зөвшөөрөгдөхийг хүсдэг. Эмэгтэй (эхнэр) та нөхрөө гэртээ ирээд (ажлынхаа талаар дутуу, илүү ярьдаг) ярьсан зүйлийг нь хүлээн зөвшөөрч байх нь зүйтэй. Эмэгтэй (эхнэр): “Гэртээ тамхи татахаа боль” гэдгийг хэлбэл эр хүн намайг захирах гээд байна гэж боддог. Эндээс үүдэн дараахи зүйлийг анхаарвал зүйтэй.

- Эр хүн толгойгоо ажиллуулдаг,
- Эм хүн зүрх сэтгэлээрээ ханддаг,
- Эр хүн хий гэсэн юмаа гүйцээж байж санаа нь амардаг,
- Эм хүн харилцааг чухалчилдаг,
- Эр хүн амжилтандаа сэтгэл хангалуун байдаг,
- Эм хүн зорилго руу бус, ямар нэг харилцаа руу чиглэдэг,
- Эрчүүд ажил төвтэй, ажлын төлөө төрдөг гэдэг.

Чухам эндээс л ялгаатай байдал зөрчлүүд үүсдэг.

Гэр бүлийн гишүүн бүхэн бие биенийхээ төлөө өөрсдийгөө зориулах хэрэгтэй дээ.

Зан араншингийн ялгаа:

- Тухайн гэр бүлийн эхнэр, нөхөр төдийгүй хүүхдүүд нь ч хоорондоо ялгаатай байдаг. Үүний гол нь учрыг хаанаас хайх вэ? Өрх бүлийнхнийгээ зан араншингийн дагуу бид хүлээн авах ёстой. Ургийн зураглалаа эргэн харах учиртай. Аав нь ээжид сайн ханддаг айлын хүү гэр бүл болоод эхнэртээ аавынхаа адил ханддаг. Ижийн хувьд ч охиндоо тийм ханддаг бол охин нь гэр бүлдээ мөн адил ханддаг.
- Зан араншингийн ялгаанд хүний бага нас нөлөөлдөг. Багадаа зодуулж, загнуулж өссөн хүн том болоход амьдралын явцад « Хүн зодох, загнах » гээд байгаа юм шиг бодол төрөөд байдаг болчихдог. Багадаа эцэг нь чанга хүмүүжүүлж өссөн охин /эхнэр/ хадамд гараад « Нөхрийнхөө дэргэд хөдөлж чадахгүй юм шиг байдаг » гэдэг.
- Эхнэр нөхрийн харилцааны түвшин бус байдал хүүхдийн нь бага насанд хүчтэй нөлөөлж, сайн хийгээд муу ул мөрөө үлдээдэг. Өөрөөр хэлбэл бага насны сэтгэлийн шарх тод үлддэг. Хүн өөрийгөө бусдын зан чанарт тохируулж гэрлэдэг мөртлөө гэрлэсний дараа өөрийнхөө зан чанарт бусдыг тохируулахыг хичээдэг. Тэгснээс болоод харилцааны зөрчлүүд үүсдэг.

Танай гэр бүлийн харилцаанд дараах байдал гардаг уу? (Дүгнэлт хийгээрэй.)

- Маргалдах
- Тоомсоргүй, хүндэтгэлгүй харьцах,
- Удаан хугацаагаар хөндий байх,
- Хардах
- Зодолдох,
- Түр хугацаагаар салах,
- Хүсээгүй бэлгийн харилцаа зэрэг,

Гэр бүлийн асуудлаар Та хэнтэй санал бодлоо хуваалцахыг хүсдэг вэ?

- Найз нөхөдтэйгээ,
- Эх, эцэгтэйгээ,
- Өөрөө бие дааж, өөрөө шийдэх,
- Гэр бүлд зөвлөгөө өгөх төвд, сэтгэл зүйчид хандах зэрэг.өө